



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/259

Улаанбаатар хот

### Барилга байгууламж балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн ерөнхий боловсролын 59 дүгээр сургуулийн балансад бүртгэлтэй, нийт 2,498,795,198.20 (хоёр тэрбум дөрвөн зуун ерэн найман сая долоон зуун ерэн таван мянга нэг зуун ерэн найман төгрөг хорин мөнгө) төгрөгийн үнэ бүхий, хавсралтад заасан барилга байгууламжийг нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургуулийн балансад шилжүүлэн данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 59 дүгээр сургууль (Н.Цэвэгмэд)-д зөвшөөрсүгэй.

2. Балансаас балансад шилжин ирж буй хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургууль (Д.Нэргүй)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201100

Нийслэлийн Засаг даргын 2023 оны  
 05 сарын 14-ны өдрийн  
 захирамжийн  
 хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалта д орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл (2022.12.31)	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Сургуулийн барилга	Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороолол	2016.09.01	м.кв	2660	2,231,445,108.70	362,766,609.88	1,868,678,498.82	Нийслэлийн ерөнхий боловсролын 156 дугаар сургууль
2	Уурын зуухны барилга		2016.09.01	ш	1	90,460,000.00	10,028,333.40	80,431,666.60	
3	Дэд станц /380v/		2016.09.01	ш	1	7,772,776.00	647,731.20	7,125,044.80	
4	Цэвэр усны шугам		2016.09.01	у/м	73,50	3,609,970.14	360,997.20	3,248,972.94	
5	Бохир усны шугам		2016.09.01	у/м	72,50	13,516,708.60	1,126,392.60	12,390,316	
6	Цахилгааны шугам		2016.09.01	у/м	480	13,685,236.80	1,140,436.20	12,544,800.60	
7	Гадна холбооны шугам		2016.09.01	у/м	800	29,454,648.00	2,454,553.80	27,000,094.20	
8	Гадна дулааны шугам		2016.09.01	у/м	292	76,587,176.20	6,382,264.80	70,204,911.40	
9	Гадна хашаа		2016.09.01	м.кв	276.76	32,263,573.76	16,131,786.60	16,131,787.16	
Нийт үнэ						2,498,795,198.20	401,039,105.68	2,097,756,092.52	